



ХАРХОРИН ХУВЬЦААТ КОМПАНИ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 он



1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Хархорин ХК

Хаяг: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэ-толгой баг, Усжуулахын контор

Утас: 70327890

Факс: 70151955

Электрон хаяг: kh.kh_jsc@yahoo.com

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

1.	Оноосон нэр	Хархорин
2.	Хариуцлагын хэлбэр	Нээлттэй Хувьцаат Компани
3.	Регистрийн дугаар	2015471
4.	Улсын бүртгэлийн дугаар	1010001006
5.	Үүсгэн байгуулагдсан огноо	1996.04.29
6.	Үндсэн эрхлэх үйл ажиллагаа	Чацаргана тариалах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Үнэт цаас гаргагчийн зорилго: Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт тэргүүлэгч, чацаргана тариалагч, чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж болох.

Үйл ажиллагааны стратеги: “Хархорин” ХК нь Монгол Улсад төдийгүй дэлхийд томоохонд орох нийт 3,000 гаруй га талбай бүхий чацарганы “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнээс 2007 – 2016 онд нийт 600 гаруй га талбайд чацаргана тариалаад байгаа бөгөөд чацарганы ургацын хэмжээ жил тутам нэмэгдэж байна.

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

Тус “Хархорин” ХК нь Монгол Улсын эртний нийслэл Хархорин хот, одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэтолгой багийн нутаг дэвсгэрт байрлаж байна. Хархорин сум нь Улаанбаатар хотоос баруун тийш 360 км, Өвөрхангай аймгаас зүүн хойш 130 км зайд оршдог.

Хархорин ХК нь анх 1956 онд БНМАУ-ын Засгийн газрын 100% хөрөнгө оруулалтаар Хархорин сум САА нэртэйгээр газар тариалан, мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн түүхтэй Монголын томоохон САА нэг юм. 1990 онд Монгол оронд Ардчилсан хувьсгал гарч ирсэнээр 1992 онд тус САА нь Хархорин ХК нэртэйгээр төрийн өмч хувийн өмчид шилжин 70% төр, 30% тухайн нутгийн ард иргэдэд өмчлөн холимог системээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 1992 оноос тус компанийн хэвийн ажиллагаа доголдож 2007 онд өмч хувьчлал буюу нээлттэй тендэр зарлан 100%, хувийн өмчид

шилжсэн. Шилжсэн цагаас хойш тус компани нь өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөн Монгол Улсын засгийн газраас баталсан “Чацаргана”, “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд, чацаргана үржүүлэх, тариалах чиглэлээр нийт 200 гаруй ажилтан албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь Ерөнхий агрономич Л.Бямбасүрэнгээр ахлуулсан 6 бригад, бригадыг ахалсан мэргэжлийн 6 агрономичтойгоор агроүйлдвэрлэл явуулж байна. Компанийн эзэмшлийн газар нутгийн хувьд 4000 гаруй га талбай, Орхон голоос эх авсан усалтын 13 м сувагтай 2007 оноос эдүүгээ нийт 600 гаруй га талбайд чацарганы жимст цэцэрлэг байгуулах ажлыг амжилттай байгуулан ажиллаж байна. Мөн 2014 он ОХУ-аас гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө, алим гэх мэт төрлийн жимслэг ургамлыг нутагшуулах ажлыг зохион байгуулж байна.

“Хархорин” ХК нь Монгол Улсад хамгийн томд орох таримал чацарганы талбайтай бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажилласан тохиолдолд жилд нийт 2,000 гаруй тонн чацарганы жимс хураан авч дотоодын чацаргана боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх хүчин чадалтай.

Монголын Чацарганы холбооноос авсан мэдээллээр одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 40 гаруй том жижиг чацаргана боловсруулах үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрийн нийт хүчин чадлын хэмжээ нь жилд 5,000 орчин тонн түүхий чацаргана боловсруулах боломжтой. Үүнээс үзвэл “Хархорин” ХК нь дангаараа Монгол Улсын чацаргана боловсруулах үйлдвэрүүдийн нэг жилийн түүхий эдийн хэрэгцээний 40%-ийг хангах бололцоотой.

5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:

2016 онд “Хархорин” ХК-ийн бараа бүтээгдэхүүний гол зах зээл болох жимс, жимсгэнэ, тэр дундаа чацарганы дотоод болон гадаад зах зээлд томоохон өөрчлөлт гараагүй болно.

“Хархорин” ХК нь 2016 онд чацарганы ургац хураалтын хувьд 570 гаруй тонн чацаргана хураасан. Энэ нь 2007 он буюу анх чацаргана тариалах үйл ажиллагаа эрхэлж эхэлнээс хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Үүнд манай компанийн чадварлаг агрономич, цэцэрлэгч, усжуулагч, механикжуулагчдын арвин их хөдөлмөрийн үр шим юм. Түүнчлэн компанийн удирдлагын зүгээс чацарганы ургацын хэмжээг нэмэгдүүлэх, нэгж талбайн гарцыг дээшлүүлэх зэрэгт анхаарлаа хандуулан ажилласан нь үүнд нөлөөлсөн.

Хэрвээ 2015 онд манай гол бүтээгдэхүүн болох чацарганы жимсний зах зээл дээрх эрэлт хэрэгцээ өмнөх жилүүдийн адилаар өндөр хэвээр байсан. Харин өнгөрсөн 2016 онд Монгол улсын эдийн засгийн хүндрэл, Монгол төгрөгийн ханш суларсан, өргөн хэрэглээ, тэр дундаа инмортын бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн зэрэг шалтгаанаар ард иргэдийн худалдан авах чадвар буурсан. Энэ нь дотоодын зах зээл дээрх чацарганы бүтээгдэхүүний борлуулалтад шууд сөргөөр нөлөөлсөн. Үүнээс үүдэн чацаргана боловсруулах, ундаа үйлдвэрлэдэг компаниуд нь манайхаас авах чацарганы хэмжээг

бууруулах болсон. 2016 онд “Хархорин” ХК нь хэдийгээр өндөр ургац хураасан ч гэсэн, хураасан чацарганаа дотоодын үйлдвэрүүдэд чацарганы борлуулалтад сөргөөр нөлөөлсөн.

Иймд манай компани төдийгүй Монгол Улсын чацаргана тариалагч, чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн өмнө тулгамдаад байгаа гол асуудал нь Монгол Улсын хэмжээнд гадаад, дотоодын зах зээл дээрх эрэлтийг хангахуйц чацарганы түүхий эдийн хангалттай хэмжээний, чанарын тодорхой стандартын нөөцийг бий болгох, үүн дээрээ суурилан чацарганы бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гаргах болоод байна.

6. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулга:

П.Бишрэл	ТУЗ-ийн Дарга
Л.Хосбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн, Аудитын хорооны гишүүн
О.Төмөрбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин, урамшууллын хорооны дарга
Ц.Энх-Амгалан	ТУЗ-ийн ердийн гишүүн, Аудитын хорооны гишүүн
Ж.Энхтөр	ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга
П.Учрал	ТУЗ-ийн ердийн гишүүн
Д.Баярмаа	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх болон Цалин, урамшуулалын хороодын гишүүн
С.Амгалан	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын болон Цалин, урамшуулалын хороодын гишүүн
Б.Бүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
Р.Саранцэцэг	Гүйцэтгэх захирал
Б.Ганбат	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Д.Дашмаа	Ерөнхий нягтлан бодогч

7. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

Д.д	Хувьцаа эзэмшигчийн овог, нэр	Эзэмшиж байгаа хувьцааны тоо	Эзлэх хувь
1	Сүрэнжавын Пүрэв	377,660	70.0%
2	Лхагвасүрэнгийн Хосбаяр	101,634	18.8%

Жич: (2017 оны 3 дугаар сарын 24-ний байдлаар)

8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

“Хархорин” ХК нь өөрийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд хараат бус аудитын компани болох “Улиастай Ван Аудит” ХХК-р аудит хийлгэсэн болно. “Улиастай Ван Аудит” ХХК-ийг компанийн аудиторроор ажиллуулах шийдвэрийг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн болно. Тус аудитын компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос эрх авсан, итгэмжлэгдсэн аудитын компани юм. Хараат бус аудиторын зүгээс “Хархорин” ХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэсэн дүгнэлтийг гаргасан.

Үнэт цаас гаргагч нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2016.01.01-2016.12.31 –ний байдлаар өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажлладаг болно.

Түүнчлэн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид нь “Хархорин” ХК-ийн санхүүгийн тайлантай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

“Хархорин” ХК-ийн 2016 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт хөрөнгө 2016 оны жилийн эхэнд 6,972.2 сая.төг байсан бол жилийн эцсийн байдлаар 7,554.8 сая. төгрөг болж 8.4% өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант оны эцэст нийт 3,091,550.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй бөгөөд элэгдэл хассан дүнгээр 2,826,753.6 мян.төгрөг байна.

2016 онд гаднаас худалдаж авсан буюу өөрийн үйлдвэрлэлээс орлого авсан хөрөнгө нийт 129,663.9 мян.төгрөг Үүнд: будаа цэвэрлэгч ОВС-25 1 ш 28,000.0 мян.төг, будаа ачигч ЗПС-100-21 1ш 14,000.0 мян.төг, 14 км хашаа барьж орлого авсан дүн 26,247.3 мян. төг, биологийн хөрөнгө болох чацарганы суулгац нийт 45,000 ширхэг, үнэ 45,000 мян.төг, бусад хөрөнгө 16,416.6 мян.төг.



2017 оны 02 дугаар
сарын 23 -ны өдөр

Дугаар 90/
17

Улаанбаатар хот.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“ХАРХОРИН” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бид “ХАРХОРИН” ХК -ийн (цаашид “Компани” гэх) 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага

Эдгээр тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, үүнтэй холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагууд орно.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторовн хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт, Монгол улсын “Аудитын тухай” хуулийн дагуу гүйцэтгэв. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэдэг үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудын талаар аудитын нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Сонгон авах горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдлийн үнэлгээг багтаасан аудиторовн мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс компанийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд удирдлагын хийсэн томоохон тооцооллууд болон баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг үнэлэх ажлууд багтана.

Бидний хийж гүйцэтгэсэн аудит нь энэхүү гаргасан дүгнэлтэд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, аудитласан санхүүгийн тайлан нь "ХАРХОРИН" ХК -ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.



Зарлага болгосон үндсэн хөрөнгө бүгд 1,314,645 мян.төг Үүнд: актласан хөрөнгө 3,464.3 мян.төг, худалдсан хөрөнгө 11,180.8 мян. төг, хөрөнгө оруулалтаар тооцсон суулгац 1,300,000.0 мян.төг байна.

Тайлант жилд 462,435.0 мян. төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байсан. Үүнд мөнгөн хөрөнгө 1,864.9 мян.төг, бараа материал нийт 460,570.3 мян.төг (үүнд хүнсний материал 489.3 мян.төг, сэлбэг 7,160.8 мян.төг, шатахуун 6,082.2 мян.төг, хангамжийн материал 59,985.3 мян.төг, барилгын материал 9,036.8 мян.төг, багаж хэрэгсэл 1,904.4 мян.төг, галын түлээ 1,534.1 мян.төг, жимс жимсгэнэ 171,135.5 мян.төг, хайрга 1,902.8 мян.төг, труба 149,508.40 мян.төг, овъёос 74.0 мян.төг, ногоон тэжээл 2,156.8 мян.төг, эргэлтийн сүргийн мал 49,600.0 мян.төг) болно.

Дуусаагүй үйлдвэрлэлийн зардал 1,399,079.0 мян.төг, хөрөнгө оруулалт 1,296,918 мян.төг

Богино хугацаат авлага 1,569,589 мян.төг. Үүний задаргаа: гадны байгууллагын авлага 1,264,786.3 мян.төг, дараа тайлан гаргагчаас авлага 8,320.6 мян.төг, ажилчид бусад хүмүүсээс авах авлага 27,635.1 мян.төг, НДШ-ийн авлага 197.0 мян.төг, бусад авлага 268,650.0 мян.төг болно.

Богино хугацаат өглөг 5,510,674.1 мян.төг. Үүний задаргаа: Гадны байгууллага, дараа тайлан гаргачийн өглөг болон ажилчид хувь хүмүүсийн өглөг нийт дүнгээр 5,390,659.6

мян.төг, татварын өглөг 8,996.3 мян.төг, НДШ-ийн өглөг 2,490.2 мян. төг, цалингийн өглөг 41,450.4 мян.төг, суулгацын урьдчилж орсон орлогын өглөг 49,077.6 мян.төг, богино хугацаат зээл 18,000.0 мян.төг.

Урт хугацаат өр төлбөр: 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуу “Хархорин” ХК нь нийт **2,520,000 мян.төг.**-ийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй гэж гарсан.

Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал: Дунджаар 150 ажилчдын цалинд 472,012.1 мян.төг, НДШ-д 192,228.8 мян. төг, татварт 75,785.9 мян. төгрөгийг төлсөн байна.

Орлогын тайлан

Тайлант жилд үндсэн үйлдвэрлэлээс олсон орлого

2016 онд нийт 1,381,799.1 мян. төгрөгийн бүтээгдэхүүн орлого авсан. Үүнд: чацарганы жимс 366 тонн, чацарганы суулгац 33.9 мян. ширхэг, үхрийн нүд жимс 1.6 тонн, цагаан үхрийн нүд 1.9 кг, алим 17 кг, бөөрөлзгөнө 41.5 кг, гүзээлзгэнэ 80.3 кг, үхрийн нүдний суулгац 235 ш, хайлаасны суулгац 152 ш, улиасны суулгац 625 ш, шар хуайсны суулгац 115 ш, гүзээлзгэний суулгац 57 ш, овъёос 113,070 кг, ногоон тэжээл 1,465 боодол, мах, сүү, ноолуур зэрэг мал аж ахуйн бүтээгдэхүүнийг тус тус орлого авсан байна.

Үндсэн үйлдвэрлэлээс орлого авч байгаа бүтээгдэхүүнийг олж авах, бэлтгэхтэй холбогдож 2,632,302.3 мян. төгрөгийн зардал гарсан.

Үүнд: Мал аж ахуйн салбарт 14,801.1 мян.төг, засварын газарт 72,962.6 мян.төг, чацаргана жимсийг арчлах болон хураан авахтай холбогдож гарсан зардал ихэнх хэмгийг буюу 1,553,383.3 мян. төг болсон.

Бойжуулга болон хүлэмжийн аж ахуйн нийт зардал 685,286.4 мян.төг, хамгаалалтын албаны зардал 43,160.7 мян.төг, ус сувгийн холбогдолтой зардал 22,719.2 мян.төг, удирдлагын зардал 214,980.9 мян.төг, ойн зурвасын арчилгаа тордолгооны зардал 3,390.2 мян. төг, ОХУ-с туршилтын журмаар авч тариалсан жимсний зардал 8,198.8 мян.төг, овъёосны зардал 11,137.8 мян.төг, ногоон тэжээлийн зардал 2,281.3 мян.төг тус тус гарсан.

Үр дүнгийн тооцоо

Тайлант жилийн Борлуулалтын нийт орлого: 2,078,006.5 мян.төг;

Борлуулалтын өртөг: 1,999,145.1 мян.төг;

Борлуулалтын ашиг: 78,861.4 мян.төг;

Үйл ажиллагааны бус орлого: 149,747.9 мян.төг;

Удирдлагын зардал: 214,980.9 мян.төг.-ийг хасч

тооцоод **13,628.4 мян.** төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан. ААН-ийн орлогын албан татвар 340.7 мян.төг тооцогдож, **татварын дараах цэвэр ашиг 13,287.7 мян.төгрөг** болсон.

2016 онд манай хамт олон нь удирдлагын зөв зохион байгуулалт, ажилчдын уйгагүй хөдөлмөр, байгаль цаг уурын таатай нөхцөлийн үр дүнд ажлын өндөр бүтээмжтэй ажиллаа. Тайлант онд 212.1 тонн чацарганы жимс хураан авахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 576.1 тонн жимс хураан авч төлөвлөгөөг давуулан биелүүлэв.

Тайлан гаргасан Ерөнхий нягтлан бодогч Д.Дашмаа

8.3. Татварын тайлангийн тухай

“Хархорин” ХК нь татварын тайлангуудаа Монгол улсын Татварын багц хууль, тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд гаргаж цахимаар харъяа татварын байгууллагад илгээдэг болно.

9. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл

Тайлант хугацаанд “Хархорин” ХК нь Капитрон банкнаас нийт 686.6 сая төгрөг, Төрийн банкнаас нийт 595 сая төгрөгийн зээл авахаар компанийн ТУЗ-өөс холбогдох тогтоол, шийдвэрийг гаргуулсан боловч эдгээр тодорхой шалтгаануудын улмаас эдгээр зээлийн санхүүжилт орж ирээгүй болно. Түүнчлэн “Хархорин” ХК-ийн 2016 оны 05-р сарын 11-ний өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр “Хархорин” ХК-ийн охин компани болох “Сийбактхорн Хархорин” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа нэмж гаргах замаар нэмэгдүүлэх, нэмж гаргасан хувьцааг хөрөнгө оруулагч компанид бүхэлд нь худалдах тухай шийдвэрлэсэн. Энэ нь Компанийн тухай хуулийн дагуу их хэмжээний хэлцэлд тооцогдох тул Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлан хийсэн болно. Холбогдох тогтоол шийдвэрүүдтэй Компани дээр хүрэлцэн ирж танилцах боломжтой. Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.

10. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл

2016 онд манай “Хархорин” хувьцаат компанийн хувьд ургац тариалалт арвинтай жил болсон.

Манай хамт олон хүнсний шар алт хэмээн нэрлэгдэх байгалийн цэвэр бүтээгдэхүүн болох чацарганы жимсний олон төрөлт бүтээгдэхүүн гаргах эрхэм зорилго тавин ажиллаж байгаа билээ.

“Хархорин” ХК нь 2016 онд төлөвлөгөөт ургацаа нэг дахин давуулан биелүүлж жимст цэцэрлэгээс дараах жимсний ургацыг хураан авсан. Үүнд:

1. Гүзээлзгэнэ 80.3 кг
2. Бөөрөлзгөнө жимс 41.5 кг
3. Үхэр нүд жимс 1615.2 кг

4. Алим 17.0 кг
5. Чацаргана жимс 576.1 тонныг тус тус хураан авсан.

Бид хураан авсан чацарганы жимсээ “Живэртийн Оргил” ХХК буюу “Шар доктор” брэндийн чацарганы бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, “Хаан жимс Эс Би Ти” ХХК, “Монос фарм” ХХК зэрэг томоохон компаниудад нийлүүлж ажилласан.

Мөн газар тариалангийн бүтээгдэхүүн тариалалтын хувьд

1. Овьёос 113.1 тонн
2. Овьёосны ногоон тэжээл 1,465 боодлыг тус тус хураан авсан.

Түүнчлэн бид Хархорин суманд ажлын байр нэмэгдүүлж шинээр 100 гаруй ажлын байранд ажилтан албан хаагчдыг авч ажиллуулсан.

11. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр:

“Хархорин” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2016 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах өөрийн байранд, хурлын танхимд хуралдуулсан.

Тус хурлыг зарлан хуралдуулах асуудлыг компанийн ТУЗ 2016 оны 02-р сарын 19-ний өдрийн хурлаараа авч хэлэлцээд холбогдох үйлдвэрийг гаргасан болно. Хурлын мэдэгдлийг 2016 оны 02-р сарын 22-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

Тус ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөр тогтоож, тухайн үеийн Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-с бүртгэлийн өдрөөр гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг гаргуулан авсан болно.

Тус судалгааны дагуу тус бүр нэг саналын эрх бүхий нийт 539,515 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 576 хувьцаа эзэмшигчид 2016 оны 03-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй байсан. Эдгээр хувьцаа эзэмшигчдээс нийт 378,404 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нийт 9 хувьцаа эзэмшигч тус хуралд биечлэн оролцож саналаа өгсөн болно. Хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигч гараагүй.

Хурлын ирц 70.14 хувь болсон.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд болон эдгээр асуудал тус бүрээр хуралд оролцсон саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын тоог, хувь зэргийг дараах хүснэгтээс үзнэ үү:

Д/д	Хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах	378,404 (100%)	0	0
2	Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг батлах	378,404 (100%)	0	0
3	Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах	378,404 (100%)	0	0
4	Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	378,404 (100%)	0	0
5	“Хархорин үндэсний цэцэрлэг” төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	378,404 (100%)	0	0
6	Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайланд тусгасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь гаргасан хувьцааны дүнтэй зөрүүтэй байгаа тухай	378,404 (100%)	0	0

“Хархорин” ХК-ийн 2016 оны 03-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолуудтай Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас үзэж танилцах боломжтой.

Тус хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг 2016 оны 03-р сарын 29-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

12. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн шийдвэрүүд

Д.д	Хурал хуралдсан огноо	Хурлаар гарсан тогтоол, шийдвэр
1	2016 оны 01-р сарын 27-ны өдөр	ТУЗ-ийн 2016 оны анхдугаар хурлаар “Хархорин” ХК-ийн 2013-2015 оны 3-р улирлын хоорондох санхүүгийн тайлан, баримт материалд хийсэн дотоод хяналт шалгалтын ажлаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг хэлэлцэж, эдгээрийг арилгах үүрэг даалгаврыг санхүүгийн холбогдох ажилтнуудад өгсөн.
2	2016 оны 02-р сарын 19-ний өдөр	Тус хурлаар “Хархорин” ХК нь 2015 оны санхүүгийн жилд алдагдалтай ажилласантай холбоотойгоор 2015 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Түүнчлэн компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 03-р сарын 26-ны өдөр зарлан хуралдуулахаар шийдвэрлэж тус хурлаар хэлэлцэх асуудлуудыг тогтоож,

		хурлын дарга, тооллогын комисс, хурал зохион байгуулах комиссыг тус тус томилсон болно.
3	2016 оны 03-р сарын 09-ний өдөр	Тус хурлаар “Хархорин” ХК-ийн хөргөлттэй агуулах барих зориулалтаар Капитрон банкнаас нийт 686.6 сая төгрөг зээлэх асуудлыг хэлэлцсэн. Хурлаар зээл авах хүсэлтийг Капитрон банкинд гаргахаар шийдвэрлэж, зээлийн барьцаанд байршуулах хөрөнгийн жагсаалтыг баталсан. Түүнчлэн “Хархорин” ХК-ийн Капитрон банк, Улаанбаатар хотын банкин дахь компанийн харилдцах болон зээлийн дансуудын захиран зарцуулагчийг Гүйцэтгэх захирал Р.Саранцэцэг, Ерөнхий нягтлан бодогч Д.Дашмаа болгож өөрчилсөн.
4	2016 оны 03-р сарын 26-ны өдөр	Тус хурлаар “Хархорин” ХК нь өөрийн газар тариалангийн үйл ажиллагаанд зориулан нийт 595 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Төрийн банкнаас авах тухай асуудлыг хэлэцэж зээл авах болон тус зээлд зориулж барьцаа хөрөнгө гаргах тухай шийдвэрлэсэн.
5	2016 оны 05-р сарын 11-ны өдөр	ТУЗ-ийн хурлаар “Хархорин” ХК-ийн 100 хувийн охин компани болох “Сийбактхорн Хархорин” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмж хувьцаа гаргах замаар нэмэгдүүлэх, нэмж гаргасан хувьцааг бүхэлд нь хөрөнгө оруулагчид худалдах тухай асуудлыг хэлэлцсэн. “Сийбактхорн Хархорин” ХХК нь “Хархорин” ХК-ийн хэрэгжүүлж буй “Хархорин” үндэсний цэцэрлэг төслийн дагуу байгуулагдах 3000 га чацарганы цэцэрлэгийн төслийн хүрээнд нийт 200 га талбайд чацарганы цэцэрлэгийг хөрөнгө оруулагчын оролцоотойгоор байгуулах зорилгоор үүсгэн байгуулагдсан компани юм.
6	2016 оны 08-р сарын 15-ны өдөр	Тус хурлаар “Хархорин” ХК нь өөрийн газар тариалангийн үйл ажиллагаанд зориулан нийт 595 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Төрийн банкнаас авах тухай асуудлыг дахин хэлэцсэн. Төрийн банкны зүгээс зээлийн барьцаа хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн шаардлага тавьсан бөгөөд ТУЗ-ийн хурлаар зээл авах шийдвэрийг дахин гаргаж, зээлийн барьцаа хөрөнгийн жагсаалтыг баталсан.

13. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

“Хархорин” ХК-ийн 5% ба үүнээс илүү хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд 2016 онд дараах өөрчлөлт орсон болно. Үүнд:

5% ба үүнээс дээш хувьцаа эзэмшигчид, 2016.03.04 өдрийн байдлаар хуучнаар ҮЦТТХТ ХХК-с гаргуулан авсан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалганы дагуу:

Д.д	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, хувь
1	С.Пүрэв	377,660 (70.00%)
2	Л.Чинбат	73,403 (13.61%)
3	Л.Хосбаяр	28,231 (5.23%)
4	Бусад жижиг хувьцаа эзэмшигчид (нийт 573)	60,221 (11.16%)
	ДҮН	539,515 (100%)

5% ба үүнээс дээш хувьцаа эзэмшигчид, 2017.01.02-ны өдрийн байдлаар ҮЦТХТ ХХК-с гаргуулан авсан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалганы дагуу:

Д.д	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, хувь
1	С.Пүрэв	377,660 (70.00%)
2	Л.Хосбаяр	101,634 (18.84%)
3	Бусад жижиг хувьцаа эзэмшигчид (нийт 573)	60,221 (11.16%)
	ДҮН	539,515 (100%)

“Хархорин” ХК, 2017 он